

**Статистикийн хэлтсийн 9 дугаар сарын 30-наас 10 дугаар сарын 04-ний өдрийг хүртлэх  
7 хоногт хийсэн ажлын товч мэдээ**

**2018.09.21**

**Өлгий**

1. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын байрны урд талд байршилтай Статистикийн хэлтсийн 2x4 харьцаатай самбарт статистикийн тоон мэдээллийг 1212.mn болон bayan-ulgii.nso сайтуудаас авах талаар сурталчилж байршуулав. ЗДТГазарт байршуулсан хэлтсийн мэдээллийн самбарыг тогтмол шинэчилж, хэрэглэгчдэд статистикийн тоон үзүүлэлтүүдийг цаг тухайд нь танилцуулж байна.

2. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчлэлт, өөрчлөлтүүдийг тухай бүр байжуулж ажиллаж байна.

3. Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын албан бичгийн хариуг бэлтгэж нийт 56 багийн цэргийн насны эрэгтэй 18-27 насны хүний овог, нэр, насаар жагсаалтыг бэлтгэж хүргүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар, Үндэсний Олон Нийтийн радио, телевиз, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон бусад төрийн байгууллага, хувийн аж ахуйн нэгж, иргэдэд шаардлагатай тоон мэдээллийг гаргаж өгч ажиллав.

4. 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдөр аймгийн хэмжээнд зохион байгуулах “Хоггүй Өлгий” бүх нийтийн цэвэрлэгээнд байгууллагын ажилтнууд идэвхтэй оролцож хуваарьт газраа цэвэрлэв.

5. Цаг үеийн шаардлагаар ҮСХ-оос эдийн засгийн статистик болон хүн ам, нийгмийн статистикийн чиглэлээр нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь дамжуулсан болно.

6. Мал төллөлт, бойжилтын мэдээг болон том малын зүй бус хорогдлын мэдээ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг сумуудаас нэгтгэн авч, программд оруулав.

7. Барилга, байгууламж, аж үйлдвэрийн сарын мэдээ болон Хүнсний гол нэрийн барааны үнийн мэдээг цуглуулж ҮСХ-нд дамжуулав.

Бусад ажил хэвийн явагдаж байна.

**Статистикийн хэлтэс**